

ТАНИЛЦУУЛГА

Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улс хоорондын хэлэлцээрийн төслийн тухай

Монгол Улсын Засгийн газраас хилийн чанадад оршин сууж байгаа иргэдийнхээ нийгмийн хамгааллын баталгааг хангах зорилгоор "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын Зорилт 3.1-т "Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөжүүлнэ" гэж, мөн "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 2.1.3.6-д "Гадаад улсад ажиллаж, амьдарч байгаа Монгол Улсын иргэний нийгмийн баталгааг хангах үүднээс нийгмийн хамгааллын хэлэлцээрийг үргэлжлүүлэн байгуулах" зорилт дэвшүүлж, Монгол Улсын иргэд олноор оршин суудаг улс орнуудтай нийгмийн хамгааллын салбарт хамтран ажиллах хэлэлцээрийг байгуулан хэрэгжүүлж байна.

Энэ хүрээнд Монгол Улс нь Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс, Унгар Улс, Бүгд Найрамдах Польш Улс, Бүгд Найрамдах Турк Улс болон Бүгд Найрамдах Чех Улстай нийгмийн хамгааллын салбарт хамтран ажиллах хэлэлцээр байгуулан, иргэдийн шимтгэл төлсөн хугацааг нэгтгэн тооцож тэтгэвэр тогтоох эрх үүсгэх, шимтгэл төлсөн хугацаанд ногдох тэтгэврийг харилцан шилжүүлэх, нийгмийн хамгааллын тогтолцоонд давхар хамрагдахаас урьдчилан сэргийлэх, зарим богино хугацааны тэтгэмж олгох талаар харилцан тохиролцон, хэрэгжүүлж байна.

Түүнчлэн, Бүгд Найрамдах Казахстан Улс, Бүгд Найрамдах Австри Улс (БНАУ), Австралийн Холбооны Улстай хэлэлцээр шинээр байгуулах, Оросын Холбооны Улстай байгуулсан хэлэлцээрийг шинэчлэхээр ажиллаж байна.

Энэ хүрээнд 2023 оноос Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон БНАУ-ын Нийгмийн хэрэг, эрүүл мэнд, асрахуй, хэрэглэгчийг хамгаалах яам хамтран ажиллаж, Олон улсын гэрээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт заасны дагуу "Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улс хоорондын хэлэлцээр"-ийн төслийг боловсрууллаа.

"Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улс хоорондын хэлэлцээр"-ийн төсөл нь 5 бүлэг, 26 зүйлтэй бөгөөд хоёр улсын иргэдийг нийгмийн даатгалд хамруулах, тэтгэвэр тогтоож олгоход дараах зарчмыг баримтлахаар тохиролцсон. Үүнд:

- Хэлэлцээрийн хүрээнд Хэлэлцэн тохиролцогч талуудын нийгмийн хамгааллын хууль тогтоомжийн дагуу олгох тэтгэвэр хамаарах;
- Хэлэлцээрийн хүрээнд Хэлэлцэн тохиролцогч 2 талын хууль тогтоомжийн дагуу хоёр улсад даатгалын шимтгэл төлсөн давхцаагүй хугацааг нэгтгэн тооцож, тэтгэврийн эрх үүсгэх;
- Хэлэлцэн тохиролцогч 2 талд даатгалын шимтгэл төлсөн хугацаанаас тухайн улсын хууль тогтоомжийн дагуу даатгалын шимтгэл төлсөн хугацаанд ногдох тэтгэврийг олгох.

Гадаад харилцааны яамны мэдээллээр 2023 оны байдлаар БНАУ-д Монгол Улсын 2,577 иргэн оршин сууж байгаагаас 1,670 иргэн ажил хөдөлмөр эрхэлж байгаа бол Гадаадын иргэн, харьяатын газрын 2024 оны мэдээллээр Монгол Улсад БНАУ-ын 31 иргэн оршин сууж байна.

Иймд Монгол-Австрийн шинжээчдийн 2024 оны 03 дугаар сарын 11-ний өдрөөс 13-ны өдөр Улаанбаатар хотод хийсэн 3 дахь удаагийн хэлэлцээгээр Хэлэлцээрийн төслийг Олон улсын гэрээний тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9-т заасны дагуу үзэглэж, Хэлэлцэн тохиролцогч талуудын үндэсний хууль тогтоомжийн дагуу холбогдох арга хэмжээ авахаар тохиролцсон. Хэлэлцээрийн төсөлд Засгийн газрын гишүүдээс санал авч, саналыг тусгасан болно.